

ЦАГДААГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЁС ЗҮЙ, ХАРИЛЦААНЫ СОЁЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Б.Даваахүү

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8011 дүгээр дамжааны суралцагч, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Цагдаагийн удирдах ажилтны ёс зүй, ур чадвар, харилцааны соёл, тэдгээрийн ач холбогдол, харилцан хамаарлыг тодорхойлох, удирдах ажилтныг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа явуулж түүний үндсэн дээр удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх, улмаар цагдаагийн байгууллагын стратеги удирдлагын хэрэгжилтэд удирдах ажилтны хөгжлийн талаар судалгааны үндэстэй санал зөвлөмж гаргахад чиглэнэ.

Abstract: Conducting research aimed at determining the ethics, skills, and communication culture of police managers, their importance and interrelationship, and developing managers. to make recommendations.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, алба хаагч, сахилга, харилцааны ёс зүй.

Key words: Police, officers, discipline and communication ethics.

Оршил. Аливаа менежменттэй байгууллага иргэд, байгууллагын үйл ажиллагааны амжилт, ололт зөв менежмент, сайн удирдагчаас шууд хамаарна. Энэ ч утгаараа удирдах ажилтны харилцааны соёлыг дээшлүүлэх, тэдний мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх нь юу юунаас чухал бөгөөд энэ нь цаашдаа байгууллагын хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлөх гол үндэс болох учиртай.

“Удирдахад ухаан, ажиллахад арга” гэсэн монгол ардын зүйр үг байдаг. Өнөөдрийн нийгмийн хэрэгцээ, шаардлагаар “тогтвортой менежмент, шинэлэг, бүтээлч сэтгэлгээ байгууллагын хөгжил, дэвшилд амжилт авчрах гол эх үүсвэр болно” гэж үзэх болсон. Мэдээж чадварлаг удирдлага, сайн

менежменттэй байгууллага иргэд, олон нийтийн итгэл, дэмжлэгийг байнга хүлээж, түүний нийгэмд эзлэх байр суурь, хөгжилд шууд нөлөө үзүүлдэг.

Удирдахуйн ухаанд суралцаж, ёс зүй, харилцааны ур чадвар, түүний мөн чанар, нийгмийн хэрэгцээ шаардлагыг бүрэн танин мэдээгүй удирдах ажилтан өөрөө удирдах биш хамт олныхоо итгэлийг алдах ч сөрөг үр дагавартай.

Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1. дэх хэсэгт цагдаагийн байгууллагыг “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба ”

гэж тодорхойлсон. Хэдийгээр энэхүү чиг үүрэг нь хуулиар цагдаагийн байгууллагад ногдож байгаа ч түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн дэмжлэг, туслалцаа, итгэл туйлаас чухал бөгөөд үүнийг нэг талаас цагдаагийн бүх шатны удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёл, ур чадвараар дамжуулан олж авах учиртай.

Тэгвэл “Цагдаагийн удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёл ямар түвшинд байна вэ? Энэ нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу?” гэдэг нь анхаарал татах асуудал болж байна. Цагдаагийн зарим удирдах ажилтан байгууллага, нэгжийг удирдах мэргэжлийн ёс зүй, хамт олныг удирдах чадвар, бүтээлч сэтгэлгээ, харилцааны өндөр ур чадвар, соёлыг эзэмшсэн байхад сайн жишээний хажуугаар саар зүйл байсаар байна.

Түүнчлэн үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, үйл ажиллагаа нь тасралтгүй байх, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтална.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4 дүгээр зүйлд “Хууль сахиулах салбарын эрх зүйн орчныг сайжруулан, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлэх”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны

хөтөлбөрийн 4.4.12 дугаар зүйлд3 “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох эрх зүйн орчныг боловсронгуй болгох” зорилтуудыг дэвшүүлсэн.

Удирдах албан хаагчдаас гаргах сахилга, ёс зүйн зөрчил дутагдлыг бууруулах, цаашлаад байгууллагын хүний нөөцийн аюулгүй байдлыг хангах, мэргэшсэн боловсон хүчний хэрэгцээ шаардлага байгаа учраас энэхүү сэдвийг сонгон судалгааны ажлаа хийсэн болно.

Үндсэн хэсэг

Орчин үеийн нийгмийн хөгжлийн чиг хандлагыг дагаад улс, орон асар хурдацтай өөрчлөгдөн хөгжиж, дэвшиж байгаа энэ цаг үед хүн бүр нийгмээ дагаад өөрчлөгдөж, удирдах ажилтан өөрийгөө хөгжүүлэх илүү ихийг сурч мэдэн цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхах зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Цагдаагийн удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёл өнөөдөр хангалттай түвшинд биш, иргэд, олон нийтийн итгэл, хүндлэлийг төдийлөн хангаж чадахгүй байгаа нь шүүмжлэлд өртөж байгаа шинэ залуу удирдах ажилтан, залгамж үеийн төлөвшил, цаашлаад байгууллагын нэр хүнд, үйл ажиллагааны амжилтад сөргөөр нөлөөлсөөр байна. Цагдаагийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тогтоох судалгаагаар 70 орчим хувь нь “дунд” буюу түүнээс доош, харин алба хаагчдын харилцааны соёлд

50 хувь нь “хангалтгүй” гэсэн үнэлгээг өгсөн байгаа нь үүний нэг тод жишээ гэж үзэж болно.

Судалгаагаар цагдаагийн байгууллага хүнд сурталтай, цагдаагийн алба хаагчид дээрэнгүй, харьцааны соёлгүй, мэдлэг, мэргэжлийн ур чадваргүй, иргэдтэй тэгш бус харилцдаг, цагдаагийн удирдлагаас албан хаагчдын ажил үүргийн хараат бус байдалд нөлөөлдөг, танил тал, мөнгөтэй хүнд үйлчилдэг гэж олон нийт дүгнэсэн байна. Нөгөө талаар иргэдээс цагдаагийн байгууллагын алба хаагчдыг дорд үзэх, гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон, түүнчлэн алба хаагчдын ажлын цаг ихэнхдээ тодорхой бус, гэр бүлдээ анхаарал тавих цаг гардаггүй зэргээс шалтгаалж алба хаагчид бухимдах, цочрол (стресс)-д орж улмаар иргэдтэй зүй бусаар харьцаж харилцааны зөрчил, дутагдал гаргаж байна.

Дээрхи үүссэн нөхцөл байдлуудад цагдаагийн удирдлага дүгнэлт хийж энэ ч утгаараа жил бүр удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх талаар томоохон зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа ч ёс, харилцааны зөрчил, дутагдал гарсаар байна.

Иймд цагдаагийн удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсч улмаар судалгааны үндэслэл бүхий санал зөвлөмж дэвшүүлэн гаргах шаардлага бий болсон байгаа нь энэхүү сэдвээр судалгааны ажил гүйцэтгэх үндэслэл болж байна.

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, түүнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, сургалт, түүний удирдлагын хэрэгжилтийн талаар магистрын түвшинд нэлээд судлагджээ. Түүнчлэн цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа, түүний удирдлага, цагдаагийн удирдах ажилтныг хөгжүүлэх чиглэлээр судалгааны ажил хийгдсэн байна.

Харин цагдаагийн удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёлыг судлах чиглэлээр дагнасан судалгааг хийж бодлого төлөвлөгөө гаргаж практикт нэвтрүүлж гарсан үр дүнгээс шалтгаалж стратеги төлөвлөгөө гаргаж ажиллах хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Дүгнэлт

Дээрх бүгдээс дүгнэж үзэхэд цагдаагийн байгууллагын удирдах ажилтны ажлын ур чадвар, манлайлал, байгууллагыг удирдах гол хүчин зүйл нь ёс зүй, харилцаа хандлагад оршиж байна гэж дүгнэж байна. Иймд цагдаагийн байгууллагын удирдах ажилтны ёс зүй, харилцааны түвшингөөс шалтгаалан алба хаагчдын ажлын цаг ихэнхдээ тодорхой бус, гэр бүлдээ анхаарал тавих цаг гардаггүй зэргээс шалтгаалж алба хаагчид бухимдах, цочрол (стресс)-д орж улмаар иргэдтэй зүй бусаар

харьцаж харилцааны зөрчил, дутагдал үйлдэгдэж байна гэж дүгнэхээр байна.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогод удирдах алба хаагчдыг нөөцөд бүртгэх, сонгон шалгаруулалт хийх зэрэг тодорхой төрлийн үйл ажиллагаа журам байдаг боловч ёс зүй, харилцаа хандлагийг төлөвшүүлэх, дээшлүүлэх чиглэлээр ямар нэгэн сургалтын хөтөлбөр байхгүй байгаа нь Монгол Улсын үндсэн хуулинд заасан “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах”, хүний эрхийг хангаж байгаа ч цагдаагийн байгууллагын чиг үүрэг, хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, иргэдтэй хууль, дүрэм, журмын хүрээнд харьцах чадваргүй, байгууллага, хамт олны нэр хүндийг унагах, сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргах үйлдэл тасрахгүй байх магадлалтай байна.

Санал

Цагдаагийн байгууллагын удирдах ажилтны албан тушаалын онцлог, хариуцсан ажил, гүйцэтгэх чиг үүргийг харгалзан ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, дасан зохицох, мэргэшүүлэх,

чиглэлээр богино болон урт хугацааны сургалт хөтөлбөр зохион байгуулах. Цагдаагийн удирдах ажилтны ёс зүй, харилцааны соёл, удирдан зохион байгуулах ур чадвар дээшилж, алба хаагчдын ажлын гүйцэтгэлд ахиц гарах, цаашлаад байгууллагын хөгжил, бүтээмж нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Цагдаагийн ажил үйлчилгээ бүх шатанд шуурхай байдлыг ханган улмаар иргэд, олон нийтийн зүгээс цагдаагийн байгууллагад итгэх итгэл дээшлэх зэрэг олон талын ач холбогдол бүрдэнэ гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичиг.
2. Төрийн албан хаагчийн ёс зүй гарын авлага УБ хот -2019 он
3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/201 дүгээр тушаал.
4. Цагдаагийн албаны тухай хууль-УБ хот-2017 он /шинэчилсэн найруулга/
5. www.slideshare.net
6. www.google.mn
7. www.legalinfo.mn
8. Цагдаагийн байгууллагын нэгдсэн сан